



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАТЕМАТИК, ТООН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Ч.Дашдаваа
Утас: 261628 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди Аудит ХХК
Захирал: Д.Эхбаяр
Утас: 7000 6948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын Санал Дүгнэлт	Error! Bookmark not defined.
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл, Шинжлэх ухааны яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАТЕМАТИК, ТООН ТЕХНОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Д.УУГАНБААТАР ТАНАА

2022.02.25 № 07/360
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 278,202.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшинээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,317,745.63</u>	<u>42,620,754.85</u>
33	АВЛАГА	-	14,536,853.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		149,777.62
33300	Татаас, санхүүжилтийн авлага		14,387,076.00
34	УРЬДЧИЛГАА	21,815,065.63	19,682,333.23
34600	Урьдчилж гарсан зардал	21,815,065.63	19,682,333.23
35	БАРАА МАТЕРИАЛ	3,502,680.00	8,401,568.00
351	Түүхий эд материал	577,500.00	4,762,900.00
35110	Тусгай зориулалттай материал	577,500.00	4,762,900.00
354	Хангамжийн материал	2,925,180.00	3,638,668.00
35410	Бичиг хэргийн материал	2,299,700.00	3,157,390.00
35420	Аж ахуйн материал	625,480.00	481,278.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>208,033,426.49</u>	<u>317,672,396.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	208,033,426.49	317,672,396.50
392	Биет хөрөнгө	208,033,426.49	317,672,396.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	213,488,716.00	383,464,629.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,892,005.09	-86,861,781.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,574,214.05	16,574,214.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,416,636.92	-6,783,803.92
39217	Ном	11,279,138.45	11,279,138.45
39301	Програм хангамж	54,770.38	54,770.38
39302	Хуримтлагдсан элэгдэл	-54,770.38	-54,770.38
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>233,351,172.12</u>	<u>360,293,151.35</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>233,351,172.12</u>	<u>360,293,151.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	233,351,172.12	360,293,151.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,560,540.88	44,560,540.88
51101	Өмч: - төрийн	44,560,540.88	44,560,540.88
512	Хуримтлагдсан үр дүн	188,790,631.24	315,732,610.47
51210	Өмнөх үеийн үр дүн	28,621,060.07	188,790,631.24
51220	Тайлант үеийн үр дүн	160,169,571.17	126,941,979.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>233,351,172.12</u>	<u>360,293,151.35</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	906,380,520.00	1,039,865,068.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,346,420.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	42,346,420.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,346,420.00	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	20,398,400.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,948,020.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,034,100.00	1,039,865,068.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	772,694,400.00	859,701,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	772,694,400.00	859,701,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,339,700.00	180,163,268.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,119,700.00	123,959,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,220,000.00	56,203,968.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	746,210,948.83	912,923,088.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	746,210,948.83	912,923,088.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,589,638.99	776,956,710.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,243,029.70	485,578,720.71
210101	Үндсэн цалин	370,583,309.80	386,140,945.71
210102	Нэмэгдэл	71,104,280.90	72,399,193.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,555,439.00	27,038,582.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,307,707.15	60,835,735.30
210201	Тэтгэврийн даатгал	38,688,974.55	43,995,999.06
210202	Тэтгэмжийн даатгал	4,079,008.14	4,880,721.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,834,623.34	3,867,615.03
210204	Ажилгүйдлийн даатгал	740,688.14	544,464.59
210205	Эрүүл мэндийн даатгал	8,964,412.98	7,546,935.50
2104	Хангамж, бараа материалын зардал	11,447,201.31	4,294,901.58
210401	Бичиг хэрэг	8,006,396.00	2,220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	348,405.31	308,899.58
210404	Ном, хэвлэл	935,000.00	33,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,157,400.00	1,733,002.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,800,000.00	19,725,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,485,700.00
210604	Урсгал засвар	12,800,000.00	15,240,000.00
2107	Томилолт, зочны зардал	777,200.00	-
210702	Дотоод албан томилолт	777,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,401,052.00	144,378,710.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,901,052.00	142,878,710.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,613,448.83	62,142,942.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,120,000.00	1,806,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,493,448.83	60,336,942.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,621,309.84	135,966,377.79

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,790,000.00	952,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,510,000.00	952,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	96,831,309.84	135,014,177.79
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	96,829,347.84	134,776,466.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,962.00	237,711.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>160,169,571.17</u>	<u>126,941,979.23</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>160,169,571.17</u>	<u>126,941,979.23</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээ ний нөөц	Хуримтлагд сан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,560,540.88		28,621,060.07	73,181,600.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,560,540.88	-	28,621,060.07	73,181,600.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			160,169,571.17	160,169,571.17
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,560,540.88	-	188,790,631.24	233,351,172.12
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,560,540.88	-	188,790,631.24	233,351,172.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,560,540.88	-	188,790,631.24	233,351,172.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			126,941,979.23	126,941,979.23
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,560,540.88	-	315,732,610.47	360,293,151.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	864,034,100.00	1,039,865,068.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,034,100.00	1,039,865,068.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	772,694,400.00	859,701,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	772,694,400.00	859,701,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,339,700.00	180,163,268.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,119,700.00	123,959,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,220,000.00	56,203,968.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	709,544,222.00	869,889,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	709,544,222.00	869,889,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,922,912.16	719,535,701.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,243,029.70	485,578,720.71
210101	Үндсэн цалин	370,583,309.80	386,140,945.71
210102	Нэмэгдэл	71,104,280.90	72,399,193.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,555,439.00	27,038,582.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,307,707.15	60,985,512.92
210201	Тэтгэврийн даатгал	38,688,974.55	44,145,776.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,079,008.14	4,880,721.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,834,623.34	3,867,615.03
210204	Ажилгүйдлийн даатгал	740,688.14	544,464.59
210205	Эрүүл мэндийн даатгал	8,964,412.98	7,546,935.50
2104	Хангамж, бараа материалын зардал	5,515,905.31	4,764,899.58
210401	Бичиг хэрэг	1,512,500.00	1,247,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	348,405.31	350,299.58
210404	Ном, хэвлэл	935,000.00	866,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,720,000.00	2,301,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,983,700.00	21,685,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	183,700.00	6,445,990.00
210604	Урсгал засвар	12,800,000.00	15,240,000.00
2107	Томилолт, зочны зардал	777,200.00	-
210702	Дотоод албан томилолт	777,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,705,370.00	144,540,578.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,205,370.00	143,040,578.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,390,000.00	1,980,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,390,000.00	1,980,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,621,309.84	150,353,453.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,790,000.00	952,200.00
213204	Ажил олгогчоос олгохбусад тэтгэмж, урамшуулал	1,790,000.00	952,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	96,831,309.84	149,401,253.79
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	96,829,347.84	134,776,466.79

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,962.00	14,624,787.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>154,489,878.00</u>	<u>169,975,913.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	154,489,878.00	169,975,913.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	154,489,878.00	169,975,913.00
2200	Дотоод эх үүсвэрээр	154,489,878.00	169,975,913.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	154,489,878.00	169,975,913.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>154,489,878.00</u>	<u>-169,975,913.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	859,701,800.00	724,925,333.21	134,776,466.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	859,701,800.00	724,925,333.21	134,776,466.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	858,749,600.00	723,973,133.21	134,776,466.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,300,200.00	485,578,720.71	114,721,479.29
210101	Үндсэн цалин	477,173,000.00	386,140,945.71	91,032,054.29
210102	Нэмэгдэл	84,688,800.00	72,399,193.00	12,289,607.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,438,400.00	27,038,582.00	11,399,818.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,040,500.00	60,985,512.92	20,054,987.08
210201	Тэтгэврийн даатгал	57,028,500.00	44,145,776.68	12,882,723.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,003,000.00	4,880,721.12	1,122,278.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,802,400.00	3,867,615.03	934,784.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,200,600.00	544,464.59	656,135.41
210205	Эрүүл мэндийн даатгал	12,006,000.00	7,546,935.50	4,459,064.50
2104	Хангамж, бараа материалын зардал	4,764,900.00	4,764,899.58	0.42
210401	Бичиг хэрэг	1,247,000.00	1,247,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,300.00	350,299.58	0.42
210404	Ном, хэвлэл	866,600.00	866,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,301,000.00	2,301,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,734,000.00	165,734,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,494,000.00	150,494,000.00	-
210604	Урсгал засвар	15,240,000.00	15,240,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,500,000.00	5,500,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	4,000,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,410,000.00	1,410,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,410,000.00	1,410,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	952,200.00	952,200.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	952,200.00	952,200.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	952,200.00	952,200.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	859,701,800.00	724,925,333.21	134,776,466.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	859,701,800.00	724,925,333.21	134,776,466.79
131001	Улсын төсвөөс санхүүжих	859,701,800.00	724,925,333.21	134,776,466.79
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45	45	-
620001	Удирдах ажилтан	1	1	-

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

620002	Гүйцэтгэх ажилтан	44	44	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45	45	-
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	42	42	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	165,538,481.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	165,538,481.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	165,538,481.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	164,968,481.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		164,968,481.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	570,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		570,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	180,163,268.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	180,163,268.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		123,959,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		56,203,968.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад худалдан авалт, тендер шалгаруулалт, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Завсар үеийн аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 10-наас 2021 оны 12 дугаар сарын 01, жилийн эцсийн аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитын менежер Д.Насанжаргал, ахлах аудитор Д.Жаргалсайхан, Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Эхбаяр нар хэрэгжүүлсэн.

Математик, тоон технологийн хүрээлэн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Математик, тоон технологийн хүрээлэнгийн тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилго, зорилт, түүний хэрэгжилтийн талаарх товч мэдээлэл:

Математик, тоон технологийн хүрээлэн нь эрхэм зорилго “Математик, тоон технологийн судалгааг хөгжүүлж, “ШИНЭ МЭДЛЭГ”-ийг бүтээнэ” гэж тодорхойлсон байна. Үүнд:

- Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх
- Математикийн салбарт хэрэгжиж буй суурь судалгааны төслүүдийг хэрэгжүүлэх
- Тусгай захиалгат бүтээгдэхүүнийг нийлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус хүрээлэн нь дотоод хяналтыг хэрэгжүүлэх алба нэгжгүй, мөн байгууллагын дүрэм журамд тодорхой асуудлыг тусгаагүй байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлалыг баримталсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Ковид-19 цар тахлын улмаас Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 746,210.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,462.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 112,052.7 мянган төгрөгөөр буюу 48.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дансны авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, цэвэр хөрөнгө, өмчийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	-	14,536.8	14,536.8
Урьдчилж гарсан зардал	21,815.0	4,793.0	(17,022.0)
Бараа материал	3,502.7	8,401.6	4,898.9
Үндсэн хөрөнгө	208,033.4	317,672.4	109,639.0
Нийт хөрөнгө	233,351.2	345,403.9	112,052.7
Өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө, өмч	233,351.2	345,403.9	112,052.7
Нийт өр төлбөр ба цэвэр	233,351.2	345,403.9	112,052.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Дансны авлага нийт 14,536.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2021 оны ШУТС-аас төслийн санхүүжилт оны төгсгөлд орж ирснээр зарцуулаагүй 14,387.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, Сангийн яамтай тооцоо нийлсэнээр авлагаар харуулсан. Үлдсэн 149.8 мянган төгрөг нь НДШ-д илүү төлсөнөөр үүсэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулжээ.
- Урьдчилж гарсан зардал 2021 онд шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг ШУТС-д “Эрдэм шинжилгээний тайлан хүлээлцэх акт”-аар “Цагирагийн радикалын онол түүний математикийн бусад салбаруудтай холбогдох нь” ШуСс2017/64 тоот төсөл, “Алсын геометр ба К-онол” ШуСс2017/76 тоот төслүүдийг хүлээлгэж өгснөөр нийт 17,885,6 мянган төгрөгийг зардлаар бүртгэсэн. Мөн Математик, тоон технологийн хүрээлэнгийн “Эрдэм шинжилгээний бүтээл” сэтгүүлийн №3-ийг хэвлүүлэхээр 833,6 мянган төгрөгийг “Чөлөөт хэвлэл” санд шилжүүлсэнээр тус тус нэмэгдсэн байна.
- Бараа материал дансны үлдэгдэл нэмэгдсэн нь оны төгсгөлд ШУТС-ийн төслийн санхүүжилтээр бэлтгэсэн материал бүрэн зарцуулагдаагүйгээс үлдэгдэл 8,401.6 мянган төгрөг болж өссөн.
- Үндсэн хөрөнгө тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 144,048.0 мянган төгрөгийн өндөр хүчин чадалтай компьютер, тоног төхөөрөмж бэлтгэж төслийн санхүүжилтээр нэн шаардлагатай 25,927.9 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж бэлтгэсэнээр хөрөнгө өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,114,411.4 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,114,411.4 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 254,709.6 мянган төгрөгөөр бууруулан 859,701.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 859,701.8 мянган төгрөгийг төсөв баталснаас улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 859,701.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 724,925.3 мянган төгрөгийг зарцуулж 134,776.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 724,925.3 мянган төгрөг буюу 84.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулалын зардлыг 91,032.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэлийн зардлыг 20,054.9 мянган төгрөгөөр тус тус дутуу буюу хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэл дутуу байгаа нь шинжлэх ухаан, технологи хөтөлбөрийн эрдэм шинжилгээ судалгаа арга хэмжээг 134,776.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	859,701.80	724,925.30	134,776.50	84.3
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	858,749.60	723,973.10	134,776.50	84.3
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	952.2	952.2	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд суурь судалгааны төслийн санхүүжилт 123,959.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон гэрээт суурь судалгааны ажлын орлого 56,203.9 мянган төгрөг нийт 180,163.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 165,538.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 14,624.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 124.4 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 84.3 хувийн биелэлттэй, буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	24.5.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	24.6	24.6	-	100.0
2	24.5.2	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	18	24	6	133.3
3	24.5.3	Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо	5	7	2	140.0
Дундаж хувь						124.4

3.8 Аудитын гол асуудал

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийг хүрээлэнд албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй холбоотой тайлбар тодруулга авахгүй, ШУТС-ийн төслийн ажлыг гүйцэтгэх гэрээгээр ажиллаж буй гэрээт ажилтнуудыг төсвөөс цалинжуулж буй нь төсвийн төлөвлөлтөөр зогсохгүй гүйцэтгэлийг тайлагнахад сөргөөр нөлөөлж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллага нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Математик, тоон технологийн хүрээлэн 2021 онд нийт 1,663,945.2 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 147,697.1 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй, 58,845.2 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитын ажлын үед залруулсан болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаанд мөрдөж ажиллах шаардлагатай байна. Тайлант онд компьютер тоног төхөөрөмжийн худалдан авалт 169,975.9 мянган төгрөг байна. Үүнээс 129,679.1 мянган төгрөгийн өндөр хүчин чадалтай сервер худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого буюу Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлсэн төслийн санхүүжилтийн хөрөнгөөр 25,927.9 мянга, өөрийн эх үүсвэрээр 14,368.9 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг тендер шалгаруулалт зохион байгуулаагүй худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг талаарх мөрдөж, ажиллаагүй тул зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.1 заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 188,524.3 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлснээс 129,679.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэхээр төлөвлөж, 58,845.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, жилийн эцсийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээг хугацаа хоцроож, 20 мэдээг байршуулаагүй зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт 80.0 хувь, 2,312.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	4,279.1	2	4,279.1	-	-	100.0
Зөвлөмж	3	2,312.4	3	2,312.4	-	-	100.0
Нийт дүн	5	6,591.5	5	6,591.5	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Математик, тоон технологийн хүрээлэнгийн төсвийн төлөвлөлт бодиттой эсэх, байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тоологод ажиглалт хийх нөхцөл байдал хязгаарлагдмал, ШУТС-аас авч хэрэгжүүлж байгаа “Физик процессын континуум-атамт загварыг хөгжүүлэх”, “Молекулын динамик загварчлал”, “Гүн сургалтанд суурилсан Монголоос Хятад руу аман яриа орчуулах түлхүүр технологиудын судалгаа” зэрэг төслүүдийн үр ашиг, зарцуулалт, төслийн хэрэгжилт, биелэлт, Шинжлэх Ухааны Академи нь дотоод хяналтыг хэрэгжүүлсэн эсэх, өгсөн зөвлөмжийн биелэлтийг дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 301,524.2 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 15,860.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 9,998.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 129,679.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 161,846.6 мянган төгрөгийн алдаа 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 285,664.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 278,202.1 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Гэрээний хугацаа дуусах болоогүй 15,860.0 мянган төгрөгийн гэрээт 4 ажлыг санхүүгийн тайланд шууд зардлаар бүртгэсэнийг урьдчилж гарсан зардлаар бүртгүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

ШУТС-ийн 9 төсөл, БШУЯ, Соёлын яам, ШУА, Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээт ажил болон төслийн ажилд олгосон 43,300.0 мянган төгрөгийн цалингаас 9,998.5 мянган төгрөгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого: 1. Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор; 2/Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд

заасан гэрээгээр тохирсон хөлс;” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажлаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч төсөвт төлж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх, төлбөрийн акт тогтоох,

4.3 Албан шаардлага

129,679.1 мянган төгрөгийн төсөвтэй “Өндөр хүчин чадалтай сервер компьютер, сервер авах” тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны 3 гишүүн гарын үсэг зураагүй, үнэлгээний хорооны гишүүд тендерийг хянан үзэх үнэлгээний заавар, маягтын дагуу үнэлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.” заалт болон Сангийн сайдын 2012 оны 9 сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх,

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалт, тендер шалгаруулалттай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн орлого 25,927.9 мянган төгрөг, өөрийн эх үүсвэрээр 14,368.9 мянган төгрөгөөр компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авахдаа харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг тус тус мөрдөж ажиллаагүй, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх,

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Хагас жилийн тайлангаар урьдчилж гарсан зардал данснаас 17,815.6 мянган төгрөгийг хааж бичсэн анхан шатны хангалттай нотлох баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, “13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх, иж бүрэн байх,

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх,

3. Дотоод хяналттай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Тайлант оны эцэст бараа материал дансны үлдэгдэл 8,401.6 мянган төгрөг бөгөөд аж ахуйн материалд тавьж олгосон 5,757.6 мянган төгрөгийн материалыг данснаас хасаагүй байгаа нь УСНББОУС 12-ын 44 дүгээр зүйл “Бараа материалыг борлуулах, солилцох буюу хуваарилах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв холбогдох орлого байхгүй бол, барааг хуваарилах буюу холбогдох үйлчилгээг үзүүлэхэд гарсан зардал гэж хүлээн зөвшөөрнө...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ашиглалтанд байгаа бараа материалыг тавьж олгох үед данснаас хасч эд хариуцагчид хариуцуулан картжуулах, УСНББОУС 12-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх,

4. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Тайлант онд дунджаар 53 ажилтан ажилласан бөгөөд үүнээс үндсэн ажилтан 22, гэрээт ажилтан 33 байна. Гэрээт ажилтануудтай байгуулсан “Эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх гэрээ”-ний 2.1.4 дэх заалтанд “Төлөвлөгөөнд тусгасан ажлын дагуу тайланг гэрээнд заасан хугацаанд хүлээн авч, хангалттай биелүүлсэн тохиолдолд ажлын хөлсийг олгохоор хүрээлэнгийн захиргаа, санхүүд хандана” гэсэн заалтыг биелүүлээгүй, сар бүр шууд уг гэрээгээр тохирсон цалинг олгож, давхардсан ажлын хөлс 20,549.0 мянган төгрөг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 6.4.2.төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилтануудад цалин, гэрээт ажлын хөлсийг давхардуулж олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх,

5. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

ШУТС-ийн сангаас хэрэгжүүлсэн гэрээт төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн анхан шатны нотлох баримтууд хангалгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4.”хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	43,300.0 мянган төгрөгийн төслийн гэрээт ажлаас 9,998.5 мянган төгрөгийн Эрүүл мэнд, НДШ суутгаагүй байна.	43,300.0 мянган төгрөгийн төслийн гэрээт ажлаас 9,998.5 мянган төгрөгийн Эрүүл мэнд, НДШ суутгаагүй байна.	1	9,998.50	-	-	1	9,998.50	-	-			-	-
2	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	ШУТС-аас 87,455.5 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 20,549.0 мянган төгрөгийг ажил үйлчилгээ гүйцэтгэсэн хөлсөнд олгосон нь давхардсан ажлын хөлс гэж үзэж байна.	ШУТС-аас 87,455.5 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 20,549.0 мянган төгрөгийг ажил үйлчилгээ гүйцэтгэсэн хөлсөнд олгосон нь давхардсан ажлын хөлс гэж үзэж байна.	1	20,549.00	-	-	-	-	-	-			1	20,549.00
3	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	Хагас жилийн тайлан гаргахдаа 17,855.6 мянган төгрөгийг хааж бичсэн.	Хагас жилийн тайлан гаргахдаа 17,855.6 мянган төгрөгийг хааж бичсэн.	1	17,855.60	-	-	-	-	-	-			1	17,855.60

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	Холбогдох баримт бичиг, бүтээгдэхүүний өмчлөх эрх шилжсэн тухай баримтууд байгаа гэж бичсэн боловч, нотлох баримт байхгүй байна.	Холбогдох баримт бичиг, бүтээгдэхүүний өмчлөх эрх шилжсэн тухай баримтууд байгаа гэж бичсэн боловч, нотлох баримт байхгүй байна.	1	87,455.50	-	-	-	-	-	-	-	-	1	87,455.50
5	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	5,757.6 мянган төгрөгийн бараа материалыг тавьж олгох үед данснаас хасаагүй.	5,757.6 мянган төгрөгийн бараа материалыг тавьж олгох үед данснаас хасаагүй.	1	5,757.60	-	-	-	-	-	-	-	-	1	5,757.60
6	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	Гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлуудыг дуусах хугацаа болоогүй, хүлээн авсан акт үйлдээгүй байхад шууд зардалд бүртгэсэн.	Гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлуудыг дуусах хугацаа болоогүй, хүлээн авсан акт үйлдээгүй байхад шууд зардалд бүртгэсэн.ийг залруулсан.	1	15,860.00	1	15,860.00	-	-	-	-	-	-	-	-
Дүн					6	157,476.20	1	15,860.00	1	9,998.50	-	-	-	-	4	131,618
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	МТТХ/202103001 тоот тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны 3 гишүүн гарын үсэг зураагүй, үнэлгээний хорооны гишүүд тендерийг хянан үзэх үнэлгээний заавар, маягтын дагуу үнэлээгүй байна.	МТТХ/202103001 тоот тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны 3 гишүүн гарын үсэг зураагүй, үнэлгээний хорооны гишүүд тендерийг хянан үзэх үнэлгээний заавар, маягтын дагуу үнэлээгүй байна.	1	129,679.10	-	-	-	-	1	129,679.10	-	-	-	
2	МТТХ	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	Худалдан авалт, тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй худалдан авсан байна.	Худалдан авалт, тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй худалдан авсан байна.	-	14,368.90	-	-	-	-	-	-	-	-	14,368.90	
Дүн					1	144,048.00	-	-	-	-	1	129,679.10	-	-	14,368.90	
Нийт дүн					7	301,524.20	1	15,860.00	1	9,998.50	1	129,679.10	-	-	4	145,986.60



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 27/А0150058
АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны 12 дугаар сард 43,300,000.00 төгрөгийн гэрээт ажлаас 9,998,587.00 төгрөгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т "Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого: 1. Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор; 2/Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс;" гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээт ажлаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй 9,998,587.00 (Есөн сая есөн зуун ерэн найман мянга таван зуун наян долоо) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Математик, тоон технологийн хүрээлэнгийн захирал Д.Ууганбаатар, ахлах нягтлан бодогч М.Буяннэмэх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Д.ЭХБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

310.10.10.201chig_KheregAkt12022/0225 Auditin 2 Gazar-27.Docx

001090100



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 164/А0150058
АХГ-2022/58/НА-СТБ-ТМС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зохион байгуулсан 129,679,110 төгрөгийн "Өндөр хүчин чадалтай сервер компьютер, сервер авах" МТТХ/202103001 тоот тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны 3 гишүүн гарын үсэг зураагүй, үнэлгээний хорооны гишүүд тендерийг хянан үзэх үнэлгээний заавар, маягтын дагуу үнэлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 "Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид "үнэлгээний дүгнэлт" гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.", 47.8 "Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Математик, тоон технологийн хүрээлэнгийн захирал Д.Ууганбаатар, ахлах нягтлан бодогч М.Буюннэмэх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

U:\10.10.20\Bichig_Kheresgallan Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-163.Docx

0010800517

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.